Дархан сум нь амьтны аймгийн төрлөөр баян нутаг билээ. Агнуурын ан амьтан. Чоно, үнэг, хярс, бор туулай, дорго, хүрнэ, мануул, цагаан зээр, тарвага зэрэг ан амьтан элбэг тааралдах ба сүүлийн жилүүдэд байгалийн хувьсан өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас тарвага, цагаан зээр зэрэг агнуурын ан амьтад эрс ховордсон байна. Ховор ан амьтан: Дархан ууланд 1980-аад оны эхээр буга согоо, аргаль угалз нутагшиж ирсэн ба ховор ан амьтны төрөлд орох гозоорой зурам нь мөн ууланд элбэг тааралдана. Аргаль угалз нь сүүлийн арваад жилд Дархан уулаас Эрэгнэг уул, Ноён Баян уул, Адагийн уулнуудад тархан нутагшиж тоо толгой нь өсөж байна. Одоогийн байдлаар буга 20 гаруй болж, аргаль хонины тоо толгой 200-д хүрчээ. Жигүүртэн шувуу: Махчин шувууд: Энэ төрлийн шувуудаас Дархан сумын нутаг дэвсгэрт бүх төрлийн бүргэд, шилийн сар, идлэг шонхор, начин шонхор, зээрд шонхор, тас, элээ, шар шувуу зэрэг шувуудаас гадна ховор шувуу болох ёл нь Дархан ууланд үзэгдэх болсон байна. Усны шувууд: Тал хөндийгөөр Монгол Улсын улаан номонд орсон нэн ховор Гангар хун, Хар тогоруу, Цэн тогоруу болон овогт тогоруунууд тааралдах ба Хэрлэн гол, нуур тойрмын хөвөө орчимд галуу, нугас, ангир, хун овогт тогоруу зэрэг усны шувууд элбэг байна. Бусад элбэг шувууд: Хөхвөр тагтаа, соотон гуйвалга, хотны бүгээхэй, хэрээ, бөвөөлжин өвөөлж, болжморууд, монгол божрог, улаавар бужмар, ногтруу, тольт дунхай зэрэг шувуудаас гадна агнуурын шувуудаас дагуурын ятуу, цагаан ятуу, тоодог шувууд тааралдана.

## 2.5. Уур амьсгал:

Дархан сумын нутаг хотгор гүдгэрийн ялгаа багатай учраас өвөл зуны температурын хэлбэлзэл төдий л их биш байдаг. Жилийн хамгийн хүйтэн сар нь I дүгээр сар бөгөөд, агаарын дундаж температур -18.1˚С, хамгийн их температур -13.4˚С, хамгийн бага температур -21.6˚С, хамгийн дулаан сар нь VII дугаар сар бөгөөд агаарын дундаж температур 20.5˚С, хамгийн их температур 23.1˚С, хамгийн бага температур 18.2˚С байдаг. Хөрсний гадаргын температурын тухайд I дүгээр сард дундаж температур -19.9˚С, хамгийн их температур -14.2˚С, хамгийн бага температур -23.3˚С, VII дугаар сард дундаж температур 25.7˚С, хамгийн их температур 28.8˚С, хамгийн бага температур 23.0˚С байдаг.

## 2.6. Нийгэм эдийн засагт нөлөөлөх байдал:

Дархан сум нь нутаг дэвсгэрийн хэмжээгээр аймгийнхаа 17 сумаас 7-р байранд ордог. Энэ нь аймгийн нутаг дэвсгэрийн 4,41%-ийг, Монгол Улсын нутаг дэвсгэрийн 0,28%-ийг тус тус эзэлдэг.

Сум нь засаг захиргааны хувьд 5 багт хуваагддаг. Үүнд: Дотуур булаг /1-р баг/ Хараат /2-р баг/ Шажин /3-р баг/ Мэргэн хошуу /4-р баг/ Бор-Өндөр /5-р баг/ зэрэг болно. Бор-Өндөрөөс 35 кв-ын цахилгаан дамжуулах шугамаар төвийн эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон. Улаанбаатар-Чойр, Замын-Үүдийн мянганы хатуу хучилттай зам нь нутгийн баруун талаар 100 км-ын зайтай өнгөрдөг.

# БҮЛЭГ 3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээг БОННҮ-ний тайланд дараах байдлаар ангилан тодорхойлсон байдаг. Үүнд:

- Болзошгүй сөрөг нөлөөллийн үнэлгээ;
- Гол сөрөг нөлөөллийн үнэлгээ.

Төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үед байгаль орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх технологийн үе шатуудыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Далд уурхайн нэвтрэлтүүд;
2. Далд уурхайн олборлолтын үйл явц;
3. Хүдрийг бутлан ангилах, гараар ангилан ялгах;
4. Өрөмдлөг тэсэлгээний ажил, тэсрэх материалын агуулах;
5. Хуучин ил уурхай ба овоолгууд;
6. Уурхайн ашиглалтын зам ба талбай;
7. Бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам ба тээвэрлэх үйл явц;
8. Ажилчдын хотхон ба түүний ашиглалтын үйл ажиллагаа;
9. Хатуу ба шингэн хог хаягдлын цэг, талбай.

## 3.1. Болзошгүй сөрөг нөлөөллүүд

Төслөөс газрын гадарга болон хэвлийд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Далд уурхайн малталтын үед аюулгүй ажиллагаа дүрэм зөрчигдөх, технологийн буруу ажиллагаанаас үүдэн хөрсний нуралт, гулгалт зэрэг осол аваар үүсэж болзошгүй
- Уурхайн захиргаанаас бүтээгдэхүүн тээвэрлэлтийн маршрутыг тогтоон баталж тэмдэгжүүлээгүй, баталсан маршрутаар хийгээгүйн улмаас олон салаа зам үүсэж болзошгүй
- Төслийн үйл ажиллагаанд хэрэглэж буй үйлдвэрлэлийн (тэсэлгээний ба бусад) болон ахуйн зориулалттай химийн бодисууд ямар нэгэн байдлаар асгарснаар газрын хэвлий болон түүний гадаргыг бохирдуулж болзошгүй;
- Уурхайн дотоод ба гадаад тээвэрлэлтийн үед их хэмжээний тоос дэгдэж ургамлан бүрхэвчид сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй;
- Шатах тослох материалыг тээвэрлэх, юүлэх, хадгалалтын горим алдагдах үед асгаралт үүсч газрын гадарга хэвлийг бохирдуулах магадлалтай, машин, техникийн ашигласан тосыг буруу хадгалах зэрэг шалтгаанаас үүдэн алдагдан газрын гадарга бохирдуулж болзошгүй;
- Уурхайн хатуу хог хаягдлын цэгийг зохих стандартын дагуу байгуулаагүй, хог хаягдлыг зохих дүрмийн дагуу зайлуулж, устгаагүйн улмаас салхи, усаар зөөгдөн ойр орчмын газрын гадаргыг бохирдуулж болзошгүй.
- Ахуйн гаралтай хатуу, шингэн хог хаягдлын зохих дүрмийн дагуу зайлуулаагүйн улмаас газрын гадарга бохирдож болзошгүй.

Агаар орчин:

- Уурхайн үйл ажиллагааны үед үүсэх тоосны тархалт төсөл хэрэгжиж буй нутгийн агаарын чанарт бохирдол үзүүлж болзошгүй;

Амьтны аймаг:

- Шөнийн цагаар уурхайн үйл ажиллагаа явагдсан нөхцөлд шөнийн амьдралтай амьтдад сөрөг нөлөөлөл учруулна. Дуу чимээ, гэрэл гарч, амьтад дайжих, махчин амьдад идэш тэжээлээ барих зэрэгт нөлөөлнө;
- Уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлтийн зам нь үйл ажиллагаанаас амьтадын аймаг, тэдгээрийн амьдралын зүй тогтолд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй
- Болзошгүй галын аюул, осол аваарийн үед гарах үнсний дэгдэлт, хорт утааны

тархалтад амьтад хордож болзошгүй зэрэг болно.

Хүний эрүүл мэнд:

- Уурхайн бүхий л үйл ажиллагаа нь “Далд уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм” болон бусад дүрэм зааврын дагуу явагдах ёстой. Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс ажиллагсадын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, амь насанд нь аюул учирч болзошгүй;

## 3.2. Гол сөрөг нөлөөлөл

***Төслөөс үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд***

| № | Төслийн гол нөлөөлөл | Нөлөөлөлд өртөгч | Хамрах хүрээ | Нөлөөллийн эрчим | Үргэлжлэх хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хөрс хуулалт | Газрын хөрс, малын бэлчээр, агаар | Төслийн нийт хугацаанд уурхайн ухаш болон гадаад овоолгын хүрээ тэлэхгүй тул олборлолтын үйл ажиллагаанаас үүдэн шинээр хөрс хуулалтын ажил хийгдэхгүй, харин уурхайн барилга байгууламж, дэд бүтэц барьж байгуулахад /зам, ШТС, Кемп, ТМА зэрэг/ үржил шимт хөрсийг хуулан авах нь зүйтэй | Бага | Төсөл хэрэгжих нийт хугацаанд |
| 2 | Хүдэр олборлолт, | Геологийн тогтоц, | 228.74мян.тн хүдэр олборлож, 150 мян.м$^3$хоосон чулуулгийн хаягдал гарна. | Хүчтэй | |
| 3 | Тээвэр | Хөрсөн бүрхэвч, агаар, ургамалан нөмрөг | Уурхайн дотоод зам 2.1км. Дотоод замын тоосжилтыг бууруулах зорилгоор хоногт 25.63м$^3$ ус ашиглана. | Бага зэрэг | Төсөл хэрэгжих нийт хугацаанд |
| 4 | Овоолго | Агаар, шимт хөрс | Өмнөх жилүүдэд үүссэн 10,2га талбайг хамарсан хоосон чулуулгийн овоолго /ТЭЗҮ-ээс үзэхэд хоосон чулуулгийн овоолго тэлэхгүй/ | Дунд зэрэг | Төсөл хэрэгжих нийт хугацаанд |
| 5 | Барилга байгууламж, дэд бүтэц | Хөрс, шимт хөрс | Зам-1.7232<br>ШТМ-0.0562<br>Кемп-0.5651<br>Дэд станц-0.0225<br>Тэсрэх материалын агуулах-1.3608 | Дунд зэрэг | Нийт төслийн хэмжээнд |

# БҮЛЭГ 4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү төслийг хэрэгжүүлэх үед технологийн онцлогоос хамааран газрын хөрс, түүний дээрх ургамал, газрын хурдас болон агаар мандалд тоос босох зэрэг сөргөөр нөлөөлөх тул байгаль орчны мониторингийг тогтмол хийх, сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилсан сэргийлэх ажлуудыг байгаль хамгаалах төлөвлөгөө, санхүүжилтдээ тусган гүйцэтгэж ажиллана.

## БҮЛЭГ 5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

***Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө***

| № | Гол ба болзошгүй сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг (сая.төг) | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө** | | | | | | | |
| 1 | Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх | Уурхайн карьер, овоолго, зам, талбайн усалгааны хэмжээ, норм, горимыг сар улирлаар, оновчтой тогтоох, технологийн замууд болон овоолго зэргийг усалж чийглэх /тодорхой ажлын график гаргах, хуурайшилттай үед усалгааны хугацааг ойртуулах/, усалгааг явуулахдаа уурхайгаас шавхан зайлуулсан усыг ашиглах | Уурхайн ашиглалтын талбайд | 2,0 | | ҮА-ны турш, сар, улирлаар | Агаарын тухай хууль 18-р зүйл, MNS5885:2008, MNS4585:2007 |
| | | Барьцалдуулагч шингэн ашиглаж автозамаас үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээ турших | Уурхайн ашиглалтын талбайд | Үйл ажиллагааны зардлаас | | 2026 | |
| | | Хайрган хучилтгүй зам дээр тээвэр хийх машины хурдыг хязгаарлаж, 30-км/цаг ихгүй анхааруулсан тэмдэг байрлуулах. | Төслийн хүрээнд | Үйл ажиллагааны зардлаас | | 2026 оны 10 сард | |
| | | Уурхайн карьер доторх болон түүнээс гарч буй замуудад хайрга чулуу дэвсэх зэргээр технологийн замыг сайжруулж тоос босохоос хамгаалах | Уурхайн ашиглалтын талбайд | Үйл ажиллагааны зардлаас | | 2026 оны 5 дугаар сараас 10 сар дуустал | |
| | | Өрөмдлөг тэсэлгээ хийх талбайг урьдчилан чийгшүүлэх | Тэсэлгээ хийх талбайд | Үйл ажиллагааны зардлаас | | Өрөмдлөг хийсэн тохиолдолд | |
| | | Агаар дахь CO2, NO2, SO2, O2, CH4-ийн болон цацраг идэвхийн агууламжийг тодорхойлуулан хяналт шинжилгээ хийлгэж байх. | Төслийн хүрээнд | ОХШХ-ийн зардлаас | | 2026 оны 9 сард 3 цэгээс | MNS(ISO)13688:2000 MNS 3306:1991 MNS 5620:2006 MNS 5623:2006 MNS 5388:2004 MNS 5389:2004 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Хүнд механизм утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах талаар засвар үйлчилгээг тогтмол явуулах | Уурхайд ажиллаж буй техникүүдэд | Үйл ажиллагааны зардлаас | Тогтмол | |
| | | Далд уурхай, овоолго, баяжуулахад ажиллаж байгаа ачих буулгах, тээвэрлэх машин техникийн бүрэн бүтэн байдал, хаалга, цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг тогтмол хийж, зөрчил илэрсэн тохиолдолд шуурхай арга хэмжээ авч байх. | Төслийн хүрээнд, уурхайд ажиллаж буй бүх машин техникүүдэд | Үйл ажиллагааны зардлаас | Техникүүдийг ажилд гаргахын өмнө | ХАБЭАТ хууль Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS 5885:2008 |
| | | Тоосноос эрүүл мэндээ хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгсэлээр, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах | Уурхайн бүх ажилчдад | ХАБЭА-н зардлаас | Өдөр бүр /эвдрэл гарах бүрд/ | |
| | | Далд уурхайн агааржуулалтын хэвийн ажиллагаанд тогтмол хяналт тавих, засвар үйлчилгээг чанартай хийж гүйцэтгэх. | Төслийн хүрээнд | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөө** | | | | | | |
| 2 | Төслийн талбайн ойр орчмын газар доорх усны түвшин уурхайн ус хэрэглээнээс үүдэн буурах | Жил бүр үйлдвэрлэлийн болон ахуйн усны хэрэглээний тооцоо хийж, ус ашиглах дүгнэлт болон ус ашиглах гэрээг холбогдох байгууллагуудтай хийж байх | Төслийн хүрээнд | Үйл ажиллагааны зардлаас | 2-р улиралд багтаан | Усны тухай хууль |
| | | Усны боломжит нөөцийн дүгнэлт болон ус ашиглах дүгнэлтэд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашиглахгүй байх | Төслийн хүрээнд | Үйл ажиллагааны зардлаас | Үйл ажиллагааны туршид | Усны тухай хууль |
| | Газрын доорх болон ил задгай ус бохирдох | Ахуйн бохир ус зайлуулах цооног байгуулах ашиглах, засаж сэлбэх | Төслийн хүрээнд | 1,0 | 2026 оны 11 сард | |
| | | Уурхайгаас ус шавхан зайлуулалт хийхэд ашиглаж буй насосд тоолуур суурилуулах, хэвийн ажиллагаанд нь байнгын хяналт тавих, усны төлбөрийг цаг тухай бүрд нь улсад төлж ажиллах | Төслийн хүрээнд | Үйл ажиллагааны зардлаас | 2026 оны 7 сард | Усны тухай хууль |
| **Хөрсөн бүрхэвч, гадаргын хэлбэрт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө** | | | | | | |
| 3 | Нефтийн бүтээгдэхийн асгарч орчны хөрс бохирдуулах | ШТМ-ыг асгарч алдагдахаас сэргийлэн стандартын шаардлага хангасан саванд хадгалах, байгаль орчныг бохирдуулахаас хамгаалах, бохирлогдсон тохиолдолд саармагжуулах, аюулгүй болгох арга хэмжээ авах | ШТМ хадгалах агуулах Засварын талбай | 1.0 | Тогтмол хугацаагаар | Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль , Газрын тухай хууль |
| | | ШТМ агуулах, машин техникээс шатах тослох материал алдагдсан тохиолдолд, тархахаас сэргийлж зориулалтын шингээгч материал ашиглах, шаардлагатай газарт хангалттай хэмжээгээр байршуулах | | 1,0 | Тогтмол хугацаагаар | |
| | | Засварын талбайд хэрэглэсэн тос, цэвэрлэх материалыг хийх тусгай сав байрлуулах. | | Үйлдвэрийн зардалд | 2026 оны 11 сард нэмэлтээр байршуулах | |
| | | Олон салаа зам хөрс эвдлэх аюултайг тооцож замын сүлжээг цэгцтэй болгож үйлдвэрийн технологийн замуудын эхэнд анхааруулах тэмдэг тавих, эвдэрч муудсаныг сайжруулан засварлах | Уурхайн дотоод замуудад | *0,5* | 2026 | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах | Уурхайн жолооч нарт | *0,1* | 2026 | |
| | | Уурхайд ажиллах машин бусад техникүүдийг шатахуунаар цэнэглэх, урсгал засвар хийхдээ зөвхөн тусгайлан зассан талбайд гүйцэтгэх; | Төслийн хүрээнд, Уурхайн эдэлбэр газарт | Үйл ажиллагааны зардлаас | 2026 | MNS 5916:2008 |
| **Ургамал ба амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх** | | | | | | |
| 4 | Уурхайн үйл ажиллагааны нөлөөллөөр ургамлан нөмрөг устах | Барилга байгууламж, ажилчдын хотхоны гадна талбайд ногоон байгууламж бий болгох зорилгоор мод сөөг тарьж ургуулах, түүнийг арчлах | Төсөл хэрэгжиж буй талбайд | Үйл ажиллагааны зардлаас | 2026 оны 10 сард | Хөрс хамгаалах, цөлжилттэй тэмцэх тухай хууль |
| | | АМТЗ-ийн талбай болон түүний орчмын 5-10 км радиусын бүсэд ургамлын гарц, төрөл зүйл болон ховор, нэн ховор ургамлын тархалт байршлын судалгааг жил бүр хийх | | | | Ургамал хамгааллын тухай хууль |
| | | *АМТЗ-ийн талбай болон түүний орчмыг 5-10 км радиусын бүсэд зэрлэг ан амьтны судалгаа хийх, тэдгээрийн амьдрах орчныг сайжруулах зорилгоор мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах* | Төсөл хэрэгжиж буй талбайн нөлөөллийн бүсэд | *0,5* | *2026 оны 9 сард* | Амьтны тухай хууль |
| | Уурхайн үйл ажиллагаан нөлөөллөөр зэрлэг амьтад дайжих, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх | Төслийн талбайд мал амьтан орж, машин механизмд дайруулж хорогдохоос сэргийлж, байнгын хараа хяналт тавих | АМТЗ-ийн талбайд | Үйл ажиллагааны зардалаар | 2026 | Амьтны тухай хууль |
| | | Уурхайн ухаш руу мал амьтан орж эндэхээс сэргийлж эрсдэл үүсэх магадлалтай газруудаар хашаажуулж сэргийлэх | Уурхайн карьер | 0.5 | 2026 | |
| | | Уурхайд ашиглах эрчим хүчний шонгоор цахилгааныг дамжуулах явцад жигүүртэн шувууд тогонд цохиулж гэмтэж бэртэхээс сэргийлсэн байдлаар хийж гүйцэтгэх | Төслийн хэмжээнд | 0,5 | 2026 | |
| | Нийт | | | 2.0 | | |

и

**“Бор хужирын хайлуур жоншны орд”-ыг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн**

***Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө***

| № | Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Ахуйн болон үйлдвэрлэл ийн хог хаягдлын нөлөөгөөр хөрс, ус, агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх | Хог хаягдлыг ангилан ялгаж, дахин ашигладаг тогтолцоог нэвтрүүлэх. | Төслөөс гарах хог хаягдал | Үйл ажиллагааны зардлаас | | 2026 | Хог хаягдлын тухай хуулийн 9-р зүйл |
| 2 | | Хог хаягдлыг цуглуулах савыг стандартын шаардлага хангасан битүүмж сайтай хийх, ажилчдын байр, оффис, агуулах зэрэг газруудад байрлуулах, тогтмол ариутгал хийж, засварлаж байх | Төслийн хүрээнд | 0.5 | | 2026 | Хог хаягдлын тухай хуулийн 15-р зүйл |
| 3 | | Хог хаягдлыг түр хадгалах цэгүүдийг хатуу хучилтай болгох, хашаажуулж бүрэн бүтэн байдалд хяналт тавих | Хог хаягдал түр хадгалах цэгүүд | 0.5 | | 2026 | |
| ***4*** | | Аюултай хог хаягдлын зэрэглэлээс хамааран хог хаягдлын цэгт хамгаалалтын бүрэн бүтэн байдлыг хангах, хатуу хучилттай болгох | | *0,3* | | 2026 | |
| 5 | | Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах, хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээг хийх. Төлбөрийг төлж ажиллах | Төслөөс гарах хог хаягдал | Үйл ажиллагааны зардлаас | | 1-р улиралд багтаан | Хог хаягдлын тухай хуулийн 9-р зүйл |
| 6 | | Уурхайн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа нүхэн жорлонг стандартын шаардлага хангасан болгох. Мөн жил бүр ариутгал халдваргүйжүүлэлт хийх. | Төслийн хэмжээнд | 0,5 | | 2026 оны 11 сар | |
| 7 | | Хог хаягдлын нэгдсэн бүртгэлийг хөтлөх. Хог хаягдлын бүртгэл, баталгаажуулалтыг үргэлжлүүлэн гүйцэтгэх. Хог хаягдалтай холбоотой бүх төрлийн мэдээллийг баримтжуулж, мэдээллийн сан үүсгэж байх. Баримтжуулалтын хүрээнд дараах үндсэн мэдээллийг хөтлөх Хог хаягдлын төрөл, Хогны хэмжээ Огноо, | Төслөөс гарах хог хаягдал | Үйл ажиллагааны зардлаас | | 2026 | Хог хаягдлын тухай хуулийн 11.3-р зүйл 2014.04.09-ны өдөр БОАЖ-ын сайдын А-116 дугаар тушаал “Хог хаягдлын улсын тоо бүртгэл |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Хог хаягдлын хэрхэн ангилсан Хог хаягдлыг хэрхэн зайлуулсан тухай | | | | хөтлөх, тайлагнах журам” тогтоох журам |
| 8 | | Дахин ашиглах боломжтой ахуйн гаралтай хатуу хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрт гэрээлэн нийлүүлэх ажлыг тогтмол хэрэгжүүлэх | Төслийн хэмжээнд | Үйл ажиллагааны зардлаас | 2026 | Хог хаягдлын тухай хууль |
| 9 | | Аюултай хог хаягдлыг ангилан ялгаж, зориулалтын саванд түр хадгалах, эрх бүхий мэргэжлийн байгууллагуудтай гэрээлэн нийлүүлэх замаар эх үүсвэр дээрээс зайлуулах арга хэмжээг хэрэгжүүлэх | Төслийн хэмжээнд | Үйл ажиллагааны зардлаар /Аюултай хог хаягдлыг хадгалах, устгах, тээвэрлэх эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээлэн ажиллах/ | 2026 /1-2 удаа/ | Хог хаягдлын тухай хуулийн 23.1-р зүйл |
| | | Нийт зардал | | | **1,7** | |

## НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн ордыг далд аргаар олборлолтын үйл ажиллагаа явуулах тул сонгосон технологийн онцлогоос хамааран нөхөн сэргээлтийн ажил хийгдэх боломжгүй тул тухайн онд техник болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөгөөгүй болно.

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээх арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж |
|---|---|---|---|---|---|
| *1* | Уурхайн ашиглалтын талбайд ногоон байгууламж үүсгэх | *Ашиглалтын жилүүдэд уурхайн тосгон болон ашиглалтын талбайн ойр орчимд ногоон байгууламж бий болгож мод, бут тарих* | Төслийн хэмжээнд | 2,0 | 2026 оны 05 сар |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Гадаад овоолгоос үүсэх тоосжилтыг бууруулах мод тарих | *Гадаад овоолгыг тойруулан зурвас байдлаар мод тарих* | | 2026 оны 10 сард |

## ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

***Биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө***

| № | Дүйцүүлэн хамгаалах зорилт | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар хүрээ | Тоо хэмжээ | Нэгжийн үнэлгээ, төг | Нийт зардал, сая.төг | Хэрэгжүүлэх хугацаа давтамж | Баримтлах хууль, журам, стандарт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Дүйцүүлэн хамгааллын хэрэгжүүлэх ажлыг хийж гүйцэтгэх | Тэрбум мод төслийн хүрээнд мод тарих, тэдгээрийг арчлах | | 500 ш | 0,01 | 4,0 | 2026 оны 05 сард | |
| | Нийт | | | | | 4,8 | | |

## НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Ашигт малтмалын талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх байхгүй. Уурхай нь үйл ажиллагаа явуулж дууссаны дараа уурхайн хаалт болон нүүлгэн шилжүүлэлт хийгдэнэ.

| № | Нөлөөлөлд өртөх иргэд | Нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хэнтий аймгийн Дархан сумын Бор хужрын уурхайн ойролцоо нутаглаж амьдардаг иргэд | Шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох, (харилцан тохиролцох замаар) | Уурхайн нөлөөлөлд өртсөн, нүүлгэн шинжлүүлэх айл өрхийн хэмжээгээр | Үйл ажиллагааны зардал | | 2026 | “Ашигт малтмалын тухай” хуулийн 41 дүгээр зүйл |
| | Нийт | | | | - | | |

и

**“Бор хужирын хайлуур жоншны орд”-ыг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн**

## ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Нөлөөлөлд өртөх түүх соёлын өвүүд | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгж өртөг | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хэнтий аймгийн Дархан сумын Бор хужрын уурхайн ойролцоо байж болзошгүй түүх соёлын өвүүд | Шаардлагатай тохиолдолд авран хамгаалах арга хэмжээ зохион байгуулах | Судалгаагаар түүх соёлын биет өв илэрвэл тухайн олдворын хүрээнд | Үйл ажиллагааны зардлаас | | 2026 он | Соёлын өвийг хамгаалах тухай хууль |

## ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

***Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний зардал***

| Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө | Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Нэгжийн өртөг мян.төг | Нийт зардал (сая.төг) | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах стандарт, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах | Цаг агаарын улирлын, сарын, долоо хоногийн, өдрийн урьдчилсан мэдээнүүдийг төслийн үйл ажиллагаанд байнга ашиглах | Үйлдвэр ажиллах хугацаанд төслийн нийт арга хэмжээнд | Үйл ажиллагааны төсөвт суулгах | | 2026 | Компанийн онцгой байдлын үед ажиллах төвөвлөгөө |
| | Гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах | “Дархан бор хужир” ХХК | 1,0 | 1,0 | 2026 | Галын аюулгүй байдлын тухай хууль, 16-р зүйл, MNS5566:2008 MNS0640:89 MNS639:89 |
| | Гал түймэртэй тэмцэх багаж хэрэгсэл, галын хор зэргийг тогтсон стандартын дагуу байрлуулж бэлэн байдлыг хангаж ажиллах | | | | | |
| | Болзошгүй ослын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах | | | | | |
| Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх | | | | | | |
| Үйлдвэрлэлийн | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих | | | | 2026 | MNS4990:2000 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж үйлдвэрлэлийн үйл ажиллагаа доголдох, зогсох | Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны сургалтыг тогтмол хугацаанд гүйцэтгэх | “Дархан бор хужир” ХХК | 1,0 | 1,0 | | MNS4969:2000 |
| | Тэсрэх бодисын агуулахын аюулгүйн бүсийг тогтоож, дэглэмийг мөрдөж ажиллах | Тэсрэх бодисын агуулах | Үйл ажиллагааны зардал | | 2026 | Тэсэлгээний аюулгүй ажиллагаан ы нэгдсэн дүрэм |
| | Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны хэрэгслээр хангах | Төслийн нийт ажилчдад | Хөдөлмөрхамгааллын зардлаас | | 2026 | |
| Нэг жилийн зардал | | | **2,0** | | | |

## ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөтэйгөөр үйл ажиллагаа явуулах, төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгчийн удирдлага хүлээнэ гэсний дагуу доорх байдлаар төлөвлөсөн болно.

***Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө ба зардал***

| Д/д | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Хугацаа, давтамж | Зардал, сая.төг | Баримтлах хууль журам, стандарт |
|---|---|---|---|---|
| 1 | Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах; | Тогтмол | - | “Байгаль хамгаалах тухай” хууль |
| 2 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах | Төлөвлөгөөнт хугацаанд | - | БОНБҮ-ний тухай хууль |
| 3 | Байгаль орчны ажилчдыг мэргэжил дээшлүүлэх сургалт, семинарт хамруулж байх | 2026 оны 07 сар | 1,0 | |
| Нийт зардал | | | 1,0 | |

и

**“Бор хужирын хайлуур жоншны орд”-ыг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн**

## ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ, ТҮҮНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ХУВААРЬ

***БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах хуваарь***

| БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд | | Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр | Мэдээллийн агуулга | Хугацааны тов | Хэлэлцүүлгээр санал авах чиглэл | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|
| Хэнтий аймаг | Байгаль орчны газар | Тайлан хүргүүлэх, ажлын хэсэгт БОХ чиглэлээр хийгдсэн ажлуудыг газар дээр нь хянуулан тайлагнах | БОМТ-ийн тухайн жилийн тайлан, Ирэх оны төлөвлөгөө | 11-р сарын 01 | Дүгнэлт гаргуулах | Төслийн талбай, уурхай |
| Дархан сум | Сумын ЗД, БОХХБайцаагч, нутгийн иргэд | Уулзалт | | 11-р сарын 20 | БОХ арга хэмжээний тайлан ирэх оны төлөвлөгөөний төсөл дээр санал авах хамтран ажиллах | Баг эсвэл сумын төв |
| Төрийн захиргааны төв байгууллага | БОУАӨЯ-ны ХБОБНУГ-т албан бичиг | Тайлан, төлөвлөгөөг цаасан болон Файл хэлбэрээр | | 11-р сарын 30 | Хянуулан батлуулах | УБ хот |
| **Дүн** | | | | | 0 | |

и

**“Бор хужирын хайлуур жоншны орд”-ыг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн**

**ОРЧНЫ ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

| № | Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд | Байршил | Хугацаа ба давтамж | Хяналт шинжилгээний ажлын хэмжээ | Нэгжийн өртөг сая.төг | Нийт зардал, сая.төг | Баримтлах стандарт ба арга, аргачлал | Дээд доод хязгаар |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| АГААРЫН ЧАНАР | | | | | | | | |
| 1 | Агаар дахь тоосжилтын хяналт: Нийт тоос (TSP), PM2.5, PM10 Тоосны уналт | Замын хажууд Далд уурхайн дотоод агаар орчин Ангилан ялгах хэсэг | 2026 оны 09 сард 3 цэгээс | Тоосжилтын хяналтын мониторингийн 3 цэгт | 0,2 | 0,3 | MNS 4585:2007 MNS:3384:1982 MNS:4048:1988 MNS 5885:2008 MNS 5013:2003 MNS 5014:2003 | PM2.5-0.05 мг/м3 PM10-0.1мг/м3 |
| | Агаар дахь CO2, NO2, SO2, O2, CH4-ийн болон цацраг идэвхийн агууламжийг тодорхойлуулан хяналт шинжилгээ хийлгэж байх. | Ангилан ялгах хэсэг | 2026 оны 09 сард 3 цэгээс | | 0,2 | 0,6 | | |
| ГАДАРГЫН БОЛОН ГАЗРЫН ДООРХ УС | | | | | | | | |
| 2 | Гадаргын болон газрын доорхи усны чанар: Гол ионы найрлага: анион, катион, микро элементийн агууламж, Усны физик үзүүлэлт Усны түвшин, :pH, өнгө, булингаршил, хуурай үлдэгдэл, эрдэсжилт, нийт хатуулаг, | Уурхайн шүүрлийн ус Уурхайн унд ахуйн хэрэглээний ус Төсөл хэрэгжих талбайн нөлөөллийн бүсийн уст цэг | 2026 оны 09 сард 3 цэгээс | Нийт 3 цэг дээр улирал тутам дээжлэлт хийж шинжлэх | 0.065 0,070 0,065 | 0.23 0,41 0,0.23 | MNS 3934:1986 - ундны болон үйлдвэрлэлийн хэрэгцээт усны химийн шинжилгээ болон дээж авах, хадгалах; | ЗДХ |
| 3. ХӨРСӨН БҮРХЭВЧ | | | | | | | | |
| 3 | Ялзмагийн агууламж, pH, давсжилт, чийгшил, NO3-N, P2O5, K2O, pH, нийт азот, нийт фосфор, | Уурхайн бүс, Нөлөөлөлд өртөөгүй талбай, шимт хөрсний овоолго дээр | 2026 оны 09 сард 3 цэгээс | Уурхайн бүсийн орчим мониторингийн 3 ш тогтмол цэгт | 0.06 | 0.46 | MNS (ISO) 5667-5:2001- усны чанар- дээжлэлт MNS 900-2010 MNS 6148;2010 MNS 4586 : 1998 | ЗДХ |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Нефть, нефтийн бүтээгдэхүүн, нүүрсустөрөгчид, хүнд металлын агууламж микробиологийн үзүүлэлт | Шатахуун ачих, буулгах, машин механизмыг шатахуунаар цэнэглэх талбай, агуулах орчимд Хоосон чулуулгийн овоолго | 2026 оны 09 сард 3 цэгээс | Уурхайн бүсийн орчим мониторингийн 2 ш тогтмол цэгт | 0.07 | 0.31 | MNS5850 : 2008 | ЗДХ |
| 4. УРГАМЛАН НӨМРӨГ, АМЬТЫН АЙМАГ | | | | | | | | |
| 5 | Ургамлын төрөл зүйл, бүрхэц %, бодгалиудын тоо; Ургамлын дундаж өндөр, Газрын гадаргуугаас дээшхи ургамлын биомасс, кг/га; | АМТЗ-ийн талбайд олборлолтод өртөгдөөгүй талбай Уурхайн орчимд | 2026 оны 09 сард | Ургамлын, Амьтны аймгийн судалгааг төсөл хэрэгжиж буй газар нутгийн орчимд | 0,5 | 0,5 | - | - |
| 6 | Амьтны төрөл зүйл, тоо толгой, шилжилт хөдөлгөөн | | | | - | - | | |
| | | | | | **3,24** | | | |

и

**“Бор хужирын хайлуур жоншны орд”-ыг далд аргаар ашиглах төслийн 2026 оны Байгаль орчны менежментийн**

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

***Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал***

| № | Арга хэмжээ | Зардал, мян.төг |
|---|---|---|
| **1** | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө | 8600,0 |
| **2** | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө | 1700,0 |
| **3** | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 2000,0 |
| **4** | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 4800,0 |
| **5** | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө | - |
| **6** | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| **7** | Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 2000,0 |
| **8** | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 1000,0 |
| **9** | Тухайн жилийн БОМТ, түүний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь | |
| **10** | Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр | 3240,0 |
| **2026 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал** | | **26340.0** |

“Дархан бор хужир” ХХК-ийн “Бор хужрын хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах төсөл”-ийн үйл ажиллагаандаа 2026 онд хэрэгжүүлэн ажиллах Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал **26340.0 мян.төг** болж байна.
***/Нэмэлт тайлбар 2026 оны БОМТ-ний барьцаа төлбөр 13170000 төгрөг бөгөөд барьцааг 2026 оны 06 сарын 02-ны өдөр 12770000 байршуулсан, зөрүү 400000 төгрөгийг 2026 оны 10 сарын 01-ны өдөр байршуулсан болно. Барьцаа тушаасан бариимтыг нэмж хавсаргав./***